

Зөрчил

НЭГ. ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ЗААСАН ИРГЭНИЙ НИСЭХИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ХОЛБООТОЙ ЗААЛТУУД:

1.4 дүгээр зүйл. Зөрчлийн тухай хууль үйлчлэх нутаг дэвсгэр, хугацаа

1. **Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол** Монгол Улсын нутаг дэвсгэрт зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд энэ хуулиар шийтгэл оногдуулж, албадлагын арга хэмжээ хэрэглэнэ.

2.1. Зөрчил

Хууль, захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн, энэ хуульд шийтгэл оногдуулахаар заасан үйлдэл, эс үйлдэхүйг зөрчил гэнэ.

3.4 дүгээр зүйл. Торгох шийтгэл

1. Энэ хуулийн тусгай ангид заасан хэмжээгээр эрх бүхий албан тушаалтнаас **мөнгөн төлбөр оногдуулахыг** торгох шийтгэл гэнэ.

2. Торгох шийтгэлийн хэмжээ нь **хүнд арваас хорин мянган торгуулийн нэгжтэй (10,000-20сая ₮)** тэнцэх хэмжээний төгрөг, **хуулийн этгээдэд нэг зуугаас хоёр зуун мянган торгуулийн нэгжтэй (100,000-200сая ₮)** тэнцэх хэмжээний төгрөг байна.

3. Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан нэг **торгуулийн нэгж** /цаашид “нэгж” гэх/ нь **нэг мянган төгрөгтэй тэнцүү** байна.

3.6 дугаар зүйл. Эрх хасах шийтгэл

1. Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдийн тодорхой мэргэжлийн үйл ажиллагаа явуулах, эсхүл бусад тодорхой эрхийг **гурван сараас хоёр жил хүртэл хугацаагаар хязгаарлах**, эсхүл зөвшөөрлийг **хүчингүй болгохыг** эрх хасах шийтгэл гэнэ.

Зөрчил	Хамаарах этгээд	Торгох болон эрх хасах шийтгэлийн хэмжээ (₮)	
		Хүн 10,000-20 сая	Хуулийн этгээд 100,000-200 сая
14.8.1. Иргэний нисэхийн багц дүрэмд заасан баримт бичгийн бүрдэлгүй, эсхүл тусгай зөвшөөрөлгүйгээр нисэхийн үйл ажиллагаа эрхэлсэн	Иргэний нисэхийн үйл ажиллагаа эрхлэгч	2 сая	20 сая
14.8.2. Хуулиар эрх олгогдсон этгээд нислэгийн аюулгүй байдлын, эсхүл аюулгүй ажиллагааны үзлэг, шалгалтыг зохих журмын дагуу хийгээгүй	Дарга, Байцаагч	- эрхийг 1 жил хасаж; - 100,000	-
14.8.3. Иргэний нисэхийн үйл ажиллагаанд нийтээр дагаж мөрдөх дүрэм, журам зөрчсөн	Бүгд	- эрхийг 1 жил хасаж; - 300,000	3 сая
14.8.4. Нислэгийн үед нислэгийг хэвээр үргэлжлүүлэх боломжгүй онцгой тохиолдлын талаар хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр мэдээлээгүй	Хөлгийн дарга	- эрхийг 1 жил хасаж; - 5,000,000	-
14.8.5. Иргэний нисэхийн үйл ажиллагаатай холбоотой хамгаалагдсан бүсэд хууль бусаар нэвтэрсэн	Бүгд	50,000	-
14.8.6. Олон улсын агаарын тээвэрлэгч нь зорчигчийн мэдээллийг агаарын хөлөг хөөрөхөөс өмнө эрх бүхий байгууллагад хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүргүүлээгүй, эсхүл мэдээллийг дутуу хүргүүлсэн	Агаарын тээвэрлэгч	-	5 сая
14.9.1. Агаарын зайн аюулгүй байдлын хяналтын үед нисэхэд ашиглах журам зөрчсөн	Агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгч	300,000	3 сая
14.9.2. Агаарын зайн хяналтын үед илэрсэн зөрчлийг таслан зогсоох ажиллагааг хэтрүүлсэн	НХҮ	50,000	500,000
14.9.3. Агаарын зайн зөрчил үйлдсэн	Агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгч	олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж	
		50,000	500,000
14.12.1. Төрийн тусгай хамгаалалтын байгууллагаас тогтоосон дэглэм зөрчиж, төрийн тусгай хамгаалалтын бүсийн агаарын зайд нисгэгчгүй, зайнаас удирддаг агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгч	Нисгэгчгүй, зайнаас удирддаг агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгч	100,000	1 сая

ХОЁР. INCIDENT - ҮГИЙН ОРЧУУЛГЫН ТАЛААР:

Англи нэр томъёо	Монгол нэр томъёо	Иргэний нисэхийн дүрмийн нэр томъёоны тайлбар, Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах Annex 13 болон Зөрчлийн тухай хуулийн нэр томъёоны тодорхойлолт
Accident (Occurrence)	Осол	<p>ИНД-ийн нэр томъёоны тайлбарт: Осол гэж аливаа этгээд нислэгийн зорилгоор агаарын хөлөгт орсон үеэс эхлэн, түүнийг орхин гарах хүртэлх цаг хугацаанд, тухайн агаарын хөлгийн үйл ажиллагаатай холбоотой гарсан дараах хэрэг явдлыг:</p> <ul style="list-style-type: none"> (1) аливаа этгээд дараах шалтгаанаар амь насаа алдах, эсхүл хүнд гэмтэх: <ul style="list-style-type: none"> (i) тухайн агаарын хөлөгт байсан; эсхүл (ii) агаарын хөлгөөс салсан эд ангийг багтаасан, агаарын хөлгийн эд ангийн шууд үйлчлэл; эсхүл (iii) тийрэлтэт хөдөлгүүрийн хийн урсгалын шууд нөлөө, <p>гэхдээ, ердийн шалтгаанаар үүссэн гэмтэл, өөрийгөө гэмтээсэн, эсхүл бусад этгээд гэмтээсэн, эсхүл зорчигч болон хөлгийн багийн хэвийн үед байдаг байрлалаас гадна нуугдсан байхад авсан гэмтэл хамаарахгүй; эсхүл</p> (2) тухайн агаарын хөлөг гэмтэлд өртсөн, эсхүл түүний хийцийн эвдрэл нь: <ul style="list-style-type: none"> (i) тухайн агаарын хөлгийн үндсэн хийцийн бөх бат чанар, техникийн үзүүлэлт, эсхүл нислэгийн үзүүлэлтэд сөргөөр нөлөөлдөг; (ii) ихэнхдээ гэмтсэн бүрдэл хэсгийг солих, эсхүл томоохон засвар хийхийг шаарддаг, <p>гэхдээ, тухайн гэмтэл нь хөдөлгүүр, түүний С-хаалт, эсхүл туслах эд ангийн гэмтлээр хязгаарлагдсан тохиолдолд хөдөлгүүрийн татгалзал, эсхүл гэмтэл хамаарахгүй; эсхүл сэнс, далавчны үзүүр, антенн, дугуй, тормоз, бүрээс болон агаарын хөлгийн арьсны жижиг хонхойлт, эсхүл цооролтоор хязгаарлагдсан гэмтэл хамаарахгүй; эсхүл</p> (3) агаарын хөлөг сураггүй алга болох, эсхүл түүнд хүрэх ямарч боломжгүй байх;
Serious incident (Occurrence)	Ноцтой зөрчил	<p>ИНД-ийн нэр томъёоны тайлбарт: Ноцтой зөрчил гэж болсон нөхцөл байдал нь осолд хүргэх дөхсөн зөрчлийг (ослын тодорхойлолт, ноцтой зөрчлийн жишээг AC 12-1-д заасан);</p>
Incident (Occurrence)	Зөрчил	<p>ИНД-ийн нэр томъёоны тайлбарт: Зөрчил гэж агаарын хөлгийн үйл ажиллагаатай холбоотой, түүний үйл ажиллагааны аюулгүй байдалд нөлөөлж байгаа, эсхүл нөлөөлж болох, ослоос бусад хэрэг явдлыг; (Incident)</p> <p>“Зөрчлийн тухай хуулийн 2.1-д: Хууль, захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн, энэ хуульд шийтгэл оногдуулахаар заасан үйлдэл, эс үйлдэхүйг зөрчил гэнэ. (Violation act)</p>
Occurrence	Хэрэг явдал	<p>ИНД-ийн нэр томъёоны тайлбарт: Хэрэг явдал гэж осол, эсхүл зөрчлийг;</p>

ГУРАВ. ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ ИРГЭНИЙ НИСЭХЭД ХАМААРАХГҮЙ БАЙХ ҮНДЭСЛЭЛҮҮД:

- Монгол Улсын Үндсэн хууль:

10.3. Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ.

- Иргэний нисэхийн тухай хууль:

2 дугаар зүйл. Иргэний нисэхийн тухай хууль тогтоомж

2.1. Иргэний нисэхийн тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль, энэ хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

- Зөрчлийн тухай хууль:

1.4 дүгээр зүйл. Зөрчлийн тухай хууль үйлчлэх нутаг дэвсгэр, хугацаа

1. Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол Монгол Улсын нутаг дэвсгэрт зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд энэ хуулиар шийтгэл оногдуулж, албадлагын арга хэмжээ хэрэглэнэ.

- Олон улсын иргэний нисэхийн тухай Чикагогийн конвенц:

Монгол Улс 1989 оны 06 сарын 30-нд Олон улсын иргэний нисэхийн тухай конвенцид нэгдэн орсноор Үндсэн хуулийн 10.3-ын дагуу Монгол Улсын дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчлэх бөгөөд Иргэний нисэхийн тухай хуулийн 2.2, Зөрчлийн тухай хуулийн 1.4.1-д заасны дагуу иргэний нисэхэд конвенцийн заалтыг баримтална.

- Хавсралт 19 Аюулгүй байдлын удирдлага:

5.3 Аюулгүй байдлын өгөгдөл болон мэдээллийг хамгаалах

5.3.1 **Стандарт** - Гишүүн улс нь Хавсралт 3-ын дагуу аюулгүй байдлын сайн дураар мэдээлэх систем болон холбогдох эх үүсвэрээс гаргаж авсан аюулгүй байдлын өгөгдөл болон мэдээллийг хамгаалах үүрэгтэй.

Тэмдэглэл - Энэ эх үүсвэрт хувийн болон байгууллагын мэдээлэл багтана.

Тэмдэглэл 1 - Шийтгэлээс ангид байх зарчим нь сайн дурын мэдээллийн үндэс суурь.

Тэмдэглэл 2 - Гишүүн улс бүр нь нислэгийн аюулгүй байдалд нөлөөлж болох тохиолдол бүрийг сайн дураар мэдээлэх тогтолцоог холбогдох хууль, дүрэм, журмыг шаардлагатай байдлаар тохируулан өөрчилж, хялбаршуулан, сурталчлахыг хөхүүлэн дэмжих ёстой.

5.3.2 **Зөвлөмж** - Гишүүн улс нь **аюулгүй байдлын заавал мэдээлэх систем** болон холбогдох эх үүсвэрээс гаргаж авсан, 5.3.1-д заасан аюулгүй байдлын өгөгдөл болон мэдээллийн хамгаалалтыг чангатгана.

Тэмдэглэл 1 - Ажилтан болон нислэгийн үйл ажиллагааны ажилтны сургалт болон туршлагаас шалтгаалсан тэдний алдаа, эсхүл үйлдлийн төлөө шийтгэл хүлээлгэхгүй байх мэдээллийн тогтолцоо нь аюулгүй байдлын мэдээллийн үндэс суурь юм.

Тэмдэглэл 2 - Аюулгүй байдлын заавал болон сайн дураар мэдээлэх системтэй холбоотой гарын авлага Аюулгүй байдлын удирдлагын зааварт (SMM)(Doc 9859) байгаа.

- Annex 19 Safety Management

5.3 Safety data and safety information protection

5.3.1 States shall accord protection to safety data captured by, and safety information derived from, voluntary safety reporting systems and related sources in accordance with Appendix 3.

Note.— Sources include individuals and organizations.

Note 1.— A non-punitive environment is fundamental to voluntary reporting.

Note 2.— Each State is encouraged to facilitate and promote the voluntary reporting of events that could affect aviation safety by adjusting their applicable laws, regulations and policies, as necessary.

5.3.2 **Recommendation.**— States should extend the protection referred to in 5.3.1 to safety data captured by, and safety information derived from, mandatory safety reporting system and related sources.

Note 1.— A reporting environment where employees and operational personnel may trust that their actions or omissions that are commensurate with their training and experience will not be punished is fundamental to safety reporting.

Note 2.— Guidance related to both mandatory and voluntary safety reporting systems is contained in the Safety Management Manual (SMM) (Doc 9859).

Чикагогийн Конвенцийн Хавсралт 19-ийн дагуу гаргасан ИНД-12:

12.63. Шийтгэлээс ангид байх

АХОШШБ болон ИНЕГ нь дараахаас бусад тохиолдолд, аливаа этгээдийн энэ дүрмийн дагуу өгсөн мэдээллийг мөрдөн шалгах, эсхүл хариуцлага тооцох зорилгоор ашиглахгүй, эсхүл ашиглах боломж олгохгүй:

- (1) тухайн мэдээлэл нь хүн, эсхүл өмч хөрөнгөд хэрэгцээ шаардлагагүйгээр аюул учруулсан үйлдэл, эсхүл эс үйлдлийг илчилсэн бол; эсхүл
- (2) хуурамч мэдээлэл өгсөн бол; эсхүл
- (3) АХОШШБ болон ИНЕГ нь мэдээллийг хуулийн дагуу, эсхүл шүүхийн шийдвэрийн дагуу гаргаж өгөх үүрэг хүлээсэн бол.

Дүгнэлт:

Зөрчлийн тухай хуулийн 1.4-т заасныг үндэслэн, Монгол Улсын 1989 онд нэгдэн орсон Чикагогийн конвенцийн Хавсралт 19-ийн 5.3 “Аюулгүй байдлын өгөгдөл болон мэдээллийг хамгаалах” заалтын дагуу ИНД-12.63-т зааснаас бусад тохиолдолд, сайн дураар мэдээлсэн зөрчлийн мэдээллийг тухайн мэдээлэл өгсөн этгээдийг шийтгэх зорилгоор дамжуулахгүй, эсхүл ашиглахгүй.

Мөн иргэний нисэхийн нислэгийн аюулгүй байдлын байцаагч нь хэрэг бүртгэл болон хөтлөлтийн үүрэг хариуцлагаас ангид байна.